Төв аймгийн Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтэс

ТӨВ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2018/4

Хүн ам, улсын бүртгэл, соёл

Хүн ам

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2018 оны эхний 4 сард төрсөн хүүхэд 737; нас барсан хүн 194; бусад аймаг, хот руу шилжин явсан 418; бусад аймаг хотоос шилжин ирсэн 731 хүн бүртгэгдлээ. Төрсөн хүүхдийн 71.8, нас барсан хүний 96.4 хувь нь хүн ам, өрхийн мэдээллийн сан(ХАӨМС)-д оруулжээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2018 оны эхний 4 сард нийт 4165 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 202; төрөөс худалдаж авсан газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 1; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 1481; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 13; бэлэглэлийн гэрээ 124; худалдах, худалдан авах гэрээ 332; өв залгамжлал 56; барьцааны гэрээ 851; бусад бүртгэл 1105-ийг тус бүр бүртгүүллээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2018 оны эхний 4 сард нийт 62 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 36; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 10; нөхөрлөл /ЗБН/ 10, /ББН/ 1; Хоршоо 2; сан 2; банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/ 1 тус бүр бүртгүүллээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2018 оны эхний 4 сард 85 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 27; гишүүн нэмэгдсэн хасагдсан 2; дүрэм шинэчилсэн 4; дахин гэрчилгээ 8; удирдлага өөрчлөгдсөн 20; үйл ажилгааны чиглэл өөрчлөгдсөн 6; дүрмийн сан нэмэгдсэн хасагдсан 9; хаяг өөрчлөгдсөн 1; нэр хэлбэр өөрчлөгдсөн 2; татан буугдсан 3; өв залгамжлал 2; салбар бүртгүүлсэн 1 тус бүр бүртгүүллээ.

Нийгмийн даатгал, нийгмийн халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2018 оны эхний 4 сард НДШ-ийн орлого 5.3 тэрбум ₮ болж төлөвлөгөө 104.5 хувь биелэлээ. Төлөвлөгөөг Баянжаргалан сум 1.1 дахин, Зуунмод 71.7%, Батсүмбэр 1.9%, Сэргэлэн 1.8% тус тус давуулан биелүүлж, бусад сумд 4.9-48.4 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 583.2 сая ₮ болж төлөвлөгөөг 100 хувь биелүүллээ.

Тэтгэвэр, тэтгэмжинд 16.1 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 79.6 хувийг өндөр настны, 10.4 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.6 хувийг тэжээгчээ алдсаны, 5.4 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 305011 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 33.9 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 24.4%; тэтгэмжийн даатгалын сангийн 61.1%; эрүүл мэндийн даатгалын сангийн 147.4%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 294.8%; ажилгүйдлийн даатгалын сангийн 41.3%-ийг тус тус бүрдүүлжээ.



Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2018 оны эхний 4 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 45474 хүнд олгож, 5.2 тэрбум ₮-ийг зарцуулж 2017 оны мөн үеэс хүний тоо 7.6 хувь 3223 хүнээр, зарцуулсан мөнгөний хэмжээ 34.5 хувь 1.3 тэрбум ₮-өөр тус бүр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 137700 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 24.4 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 18.9 хувийг халамжийн тэтгэвэр; 7.3 хувийг насны хишгийн зардал; 6.9 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 2.5 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 1.9 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж; тусламж: 1.1 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж, 0.6 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт тус бүр зарцуулжээ.

Эрүүл мэнд

2018 оны эхний 4 сард 5554 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.3 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2018 оны эхний 4 сард 408 хүүхэд мэндэлсэн нь 2017 оны мөн үеэс 8 хүүхдээр өслөө.

Он гарсаар 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үетэй ижил байна.



Эмнэлгийн мэдээгээр 2018 оны эхний 4 сард 157 хүн нас барсан нь 2017 оны мөн үеэс 17.2 хувиар өслөө. Нас барсан хүний 17.2 хувь буюу 27 нь эмнэлэгт нас баржээ. Нас баралтыг шалтгаанаар аваад үзвэл хорт хавдарын нас баралт хамгийн өндөр 23.6 хувь, гадны шалтгаан 8.9 хувийг эзлэв.

2018 оны эхний 3 сард халдварт өвчнөөр 248 хүн өвчилсөн нь өмнөх оноос 26.4 хувь буюу 89 хүнээр буурлаа. Халдварт өвчлөлийг өмнөх онтой харьцуулбал цусан суулга 2 дахин өсчээ. 10000 хүнд ногдох халдварт өвчлөл аймгийн дундаж 16 байгаа бол: Зуунмод 91, Борнуур 40, Баян 32, Сүмбэр 32 ногдлоо.

10000 хүнд ноогдох халдварт өвчний тоог газрын зургаар харуулвал.

	Интервал-хүнээр	Сумын тоо
	2-6	6
	7-11	8
	12-18	6
	19-91	5
	0	2

_ Сум хилийн зааг



АЖИЛГҮЙЧҮҮД

2018 оны 4 дүгээр сард ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 764 болж, 2017 оны мөн үеэс 93 хүнээр, өмнөх сарынхаас 101 хүнээр тус тус өсчээ.

Ажилгүйчүүдийн 47,1 хувь буюу 360 нь эмэгтэйчүүд юм. 2018 оны эхнээс 571 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 219 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 62,6 хувь буюу 137 нь эмэгтэйчүүд байв. Ажилгүйчүүдийн бүртгэлээс оны эхнээс 569 иргэн хасагдлаа.

Аймгийн бүртгэлтэй ажилгүйчүүдийн 21,2 хувь нь Борнуур суманд; 17,5 хувь нь Зуунмод суманд; 8,9 хувь нь Сүмбэр суманд; 7,5 хувь нь Батсүмбэр суманд; 6,7 хувь нь Угтаал суманд; 6,2 хувь нь Эрдэнэ суманд бүртгэгджээ.

Тайлант сард бүртгүүлсэн 279 ажилгүй иргэний 36,6 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 17,6 хувь нь шилжин суурьшсан; 5,0 хувь нь цэргээс халагдсан; 5,0 хувь нь орон тооны цомхтголд орсон; 3,2 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 1,8 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 1,4 хувь нь байгууллага татан буугдсан; 1,1 хувь нь хорих газраас суллагдсан; 0,7 хувь нь тэтгэвэрт гарсан; 0,4 хувь нь хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан; 27,2 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын түвшингөөр хуваавал 15,6% нь дээд; 3,8% нь тусгай дунд; 5,8% нь мэргэжлийн анхан шатны; 61,3% нь бүрэн дунд; 11,5% нь бүрэн бус дунд; 1,4% нь бага боловсролтой; 0,6% нь боловсролгүй иргэд юм.

Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд дунджаар 132 ажилгүйчүүд ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 15 хүнээр их байна. Аймгийн дундажтай сумдын дунджийг

харьцуулбал Батсүмбэр, Эрдэнэ, Угтаал, Баянхангай, Борнуур, Сүмбэр сумдад аймгийн дунджаас олон ажилгүйчүүд (136-599 хүн) ногдов.

Тайлант сард ажилд зуучлуулсан 32 иргэний 53,1 хувь нь бүрэн дунд; 25,0 хувь нь дээд; 12,5 хувь нь бүрэн бус дунд; 6,2 хувь нь мэргэжлийн анхан шатны; 3,1 хувь нь тусгай дунд боловсролтой иргэд юм.

2018 оны эхнээс ажлын шинэ байранд 128 иргэн ажилд оржээ. Эдийн засгийн салбарын ангилалаар ангилбал 22,7 хувь нь ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын; 18,8 хувь нь Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний; 18,8 хувь нь Боловсруулах үйлдвэрлэлийн; 9,4 хувь нь Уул уурхай олборлолтын салбарт; 7,8 хувь нь Тээвэр ба агуулахын үйл ажиллагааны; 6,3 хувь нь Боловсролын; 4,7 хувь нь Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал; 3,1 хувь нь Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны, 2,3 хувь нь барилгын; 2,3 хувь нь Зочид буудар, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний; 1,6 хувь нь Цахилгаан, хий, уур, агааржуулалтын; 0,8 хувь нь Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны; 1,6 хувь нь Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбаруудад тус тус ажилд орлоо.









Төрийн хяналт

Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2018 оны эхний 4 сарын мэдээгээр нийт 100 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 136; үүнээс тохирлын гэрчилгээ 106, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт 7863; цулын хэмжүүр 243, үүнээс жин 209, туухай 34; эзэлхүүн зарцуулалтын хэмжүүр 61, үүнээс түгээгүүрийн хошуу 46, мерник 4, сүмбэн метр 8, шингэн бүтээгдэхүүнийг хэмжих хэрэгсэл 2, усны тоолуур 1, нэг фазын тоолуур 7524, гурван

фазын тоолуур 35-ыг тус бүр баталгаажууллаа.

Санхүүгийн хяналт, шалгалт

Санхүүгийн хяналт, аудитын алба 2018 оны эхний 4 сард 42 нэгж байгууллагад хяналт, шалгалт хийж 268.8 сая ₮-ийн зөрчил, төлбөр илэрч төлүүлвэл зохих төлбөрийн барагдуулалт 59.3 хувьтай гарлаа.



Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2018 оны эхний 4 сард аймгийн хэмжээнд 228 гэмт хэрэг бүртгэгдэж 155 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 481.0 сая ₮-ийн хохирол учирлаа.

Гарсан гэмт хэргийн 26.7 хувь нь хулгай, 26.7 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний эсрэг хэрэг, 9.5 хувь нь замын осол, 9.0 хувь нь хүн амины хэрэг, 1.0 хувь нь танхай дээрэм, 27.1 хувь нь бусад хэрэг тус бүр эзлэв. Аргалант, Баян, Баянхангай, Заамар, Баянцагаан, Лүн, Сэргэлэн, Эрдэнэ сумдад 10000 хүнд 44-109 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (35)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2017 оны мөн үеэс 25 хэргээр буурлаа.

Зуунмод суманд 6 эмэгтэй, 186 эрэгтэй нийт 192 хүн эрүүлжүүлэгдсэн байна.





Гарсан гэмт хэргийн 10.3 хувь нь бүлгээр 16.2 хувь нь согтуугаар үйлдэгджээ.
Гэмт хэргийн улмаас 68 хүн гэмтэж, 16 хүн нас барлаа.





Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2018 оны эхний 4 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 677 гүйцэтгэх хуудсанд нийт 5.3 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс биелүүлбэл зохих 649 гүйцэтгэх хуудасны 4.6 тэрбум ₮-өөс 119 хуудасны 614.9 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 18.3 хувь, үнийн дүнгээр 13.3 хувь болж 2017 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 13.0 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 1.0 нэгжээр тус тус буурав.



Төсвийн орлого 2018 оны эхний 4 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 4.5 тэрбум ₮, зарлага 22.4 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 144.3 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас; хүн амын орлогын албан татвар, галт зэвсгийн албан татвар, байгалийн ургамал, түрээсийн орлого, төрийн өмч худалдсаны орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2017 оны мөн үеэс 20.7 хувь буюу 768.4 сая ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 84.4 хувийг татварын, 15.2 хувийг татварын бус орлого, 0.4 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2017 оны мөн үеэс хөрөнгө борлуулсны орлого 0.5 нэгжээр, татварын орлого 3.4 нэгжээр тус тус буурч, татварын бус орлого 4.0 нэгжээр өсөв.

Аймгийн нийт 3 шатны орлого 6.2 тэрбум ₮ болж аймгийнх 3.1 тэрбум ₮ буюу 50.0 хувь, сумынх 1.4 тэрбум ₮ буюу 22.2 хувь, улсынх 1.7 тэрбум ₮ буюу 27.9 хувийг тус бүр бүрдүүлжээ.



2017 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 78.2 хувь буюу 78.2 сая ₮-өөр буурч 285.2 сая ₮ болж, авлага 1.1 дахин буюу 114.0 сая ₮-өөр өсч 217.1 сая ₮ боллоо.



Сумд	Сумын орлогын төлөвлөгөөний биелэлт					
	төлөвлөгөө		гүйцэтгэл		хувь	
Эрдэнэ	23 140.0		**160 623.9**		694.1%	↑
Сэргэлэн	10 298.4		**52 446.9**		509.3%	↑
Мөнгөнморьт	30 084.5		**142 626.3**		474.1%	↑
Алтанбулаг	8 885.0		**31 898.9**		359.0%	↑
Жаргалант	92 055.5		**299 246.4**		325.1%	↑
Цээл	8 550.0		**20 679.4**		241.9%	↑
Заамар	31 275.5		**75 492.1**		241.4%	↑
Лүн	27 010.9		**50 637.8**		187.5%	↑
Эрдэнэсант	11 580.0		**21 568.5**		186.3%	↑
Өндөрширээт	7 275.2		**13 319.5**		183.1%	↑
Баянцагаан	3 480.0		**6 169.9**		177.3%	↑
Батсүмбэр	49 866.4		**77 174.7**		154.8%	↑
Баянчандмань	50 324.0		**77 732.0**		154.5%	↑
Бүрэн	12 628.0		**18 563.8**		147.0%	↑
Дэлгэрхаан	5 759.2		**7 382.1**		128.2%	↑
Сүмбэр	7 834.0		**9 530.3**		121.7%	↑
Борнуур	22 239.6		**26 838.0**		120.7%	↑
Баянцогт	7 623.0		**9 117.0**		119.6%	↑
Баян	24 438.4		**27 598.9**		112.9%	↑
Зуунмод	168 991.6		**184 880.0**		109.4%	↑
Угтаал	9 785.0		**10 578.4**		108.1%	↑
Баяндэлгэр	9 870.0		**9 802.3**		99.3%	↓
Баянжаргалан	7 422.5		**7 338.4**		98.9%	↓
Баянхангай	9 460.0		**9 337.4**		98.7%	↓
Архуст	6 800.4		**6 354.5**		93.4%	↓
Аргалант	9 790.0		**8 420.0**		86.0%	↓
Баян-Өнжүүл	14 698.4		**12 419.9**		84.5%	↓
Төвлөрсөн						
Дүн	671 165.5		1377 777.2		**205.3%**	

Сумд	Орон нутгийн орлогоос **Аймагт төвлөрүүлэх** төлөвлөгөөний биелэлт					
	төлөвлөгөө		гүйцэтгэл		хувь	
Заамар	217 300.0		**517 916.2**		238.3%	↑
Сэргэлэн	97 500.0		**213 627.0**		219.1%	↑
Сүмбэр	17 345.4		**37 615.1**		216.9%	↑
Эрдэнэ	87 800.0		**141 356.0**		161.0%	↑
Аргалант	33 795.4		**51 804.9**		153.3%	↑
Цээл	31 570.0		**44 892.1**		142.2%	↑
Баянцогт	37 889.2		**49 871.5**		131.6%	↑
Борнуур	60 219.8		**78 058.6**		129.6%	↑
Мөнгөнморьт	47 463.2		**60 776.7**		128.1%	↑
Алтанбулаг	75 424.1		**86 934.4**		115.3%	↑
Лүн	47 821.4		**54 600.7**		114.2%	↑
Батсүмбэр	100 036.8		**111 059.6**		111.0%	↑
Баянхангай	21 090.0		**22 768.9**		108.0%	↑
Баяндэлгэр	26 506.4		**27 111.7**		102.3%	↑
Дэлгэрхаан	19 395.0		**19 642.4**		101.3%	↑
Өндөрширээт	22 700.0		**22 206.4**		97.8%	↓
Баянчандмань	149 400.0		**146 029.4**		97.7%	↓
Бүрэн	29 550.0		**28 769.2**		97.4%	↓
Угтаал	57 998.3		**53 994.5**		93.1%	↓
Жаргалант	123 944.2		**115 120.3**		92.9%	↓
Эрдэнэсант	52 320.0		**47 989.9**		91.7%	↓
Зуунмод	1016 135.6		**924 558.3**		91.0%	↓
Баянжаргалан	27 530.0		**24 902.3**		90.5%	↓
Архуст	49 324.4		**42 790.9**		86.8%	↓
Баян-Өнжүүл	28 596.4		**22 809.9**		79.8%	↓
Баян	111 266.4		**84 500.3**		75.9%	↓
Баянцагаан	36 854.9		**25 568.5**		69.4%	↓
Төвлөрсөн	-191 024.3		**47 244.8**		-24.7%	↓
	2435 752.6		3104 520.5		**127.5%**	

Сумд	Орон нутгийн орлогоос **Улсад төвлөрүүлэх** төлөвлөгөөний биелэлт					
	төлөвлөгөө		гүйцэтгэл		хувь	
Баянчандмань	30 422.6		**234 470.6**		770.7%	↑
Эрдэнэ	7 320.0		**41 981.7**		573.5%	↑
Угтаал	5 191.8		**18 299.1**		352.5%	↑
Сүмбэр	1 046.5		**3 333.7**		318.6%	↑
Эрдэнэсант	7 628.3		**21 884.1**		286.9%	↑
Аргалант	487.6		**1 367.1**		280.4%	↑
Баян	2 093.0		**5 750.4**		274.7%	↑
Баяндэлгэр	2 418.0		**6 135.7**		253.8%	↑
Зуунмод	200 256.0		**443 865.0**		221.6%	↑
Баянхангай	239.6		**481.0**		200.7%	↑
Баянжаргалан	452.9		**898.7**		198.4%	↑
Архуст	1 227.0		**2 392.9**		195.0%	↑
Дэлгэрхаан	1 077.7		**2 020.7**		187.5%	↑
Батсүмбэр	9 221.8		**16 067.5**		174.2%	↑
Лүн	3 301.4		**4 018.9**		121.7%	↑
Заамар	828 731.0		**798 508.4**		96.4%	↓
Бүрэн	589.9		**546.0**		92.6%	↓
Өндөрширээт	575.0		**492.0**		85.6%	↓
Цээл	2 565.5		**2 153.2**		83.9%	↓
Баянцогт	1 538.4		**1 281.3**		83.3%	↓
Жаргалант	100 032.2		**82 761.4**		82.7%	↓
Мөнгөнморьт	1 215.6		**976.6**		80.3%	↓
Алтанбулаг	1 837.2		**1 159.9**		63.1%	↓
Баян-Өнжүүл	881.1		**491.5**		55.8%	↓
Борнуур	27 650.4		**15 322.7**		55.4%	↓
Сэргэлэн	15 731.0		**6 901.2**		43.9%	↓
Баянцагаан	74 333.5		**18 476.4**		24.9%	↓
	1328 065.0		1732 038.0		**130.4%**	

Сумд	Гурван шатны татварын орлогын дүнгийн төлөвлөгөөний биелэлт					
	төлөвлөгөө		гүйцэтгэл		хувь	
Эрдэнэ	118 260.0		**343 961.6**		290.9%	↑
Мөнгөнморьт	78 763.3		**204 379.6**		259.5%	↑
Сэргэлэн	123 529.4		**272 975.0**		221.0%	↑
Баянчандмань	230 146.6		**458 232.0**		199.1%	↑
Сүмбэр	26 225.9		**50 479.1**		192.5%	↑
Цээл	42 685.5		**67 724.8**		158.7%	↑
Жаргалант	316 031.9		**497 128.1**		157.3%	↑
Баянхангай	30 789.6		**32 587.2**		145.1%	↑
Лүн	78 133.7		**109 257.4**		139.8%	↑
Аргалант	44 073.0		**61 592.0**		139.7%	↑
Алтанбулаг	86 146.3		**119 993.2**		139.3%	↑
Заамар	1077 306.5		**1391 916.7**		129.2%	↑
Батсүмбэр	159 125.0		**204 301.8**		128.4%	↑
Баянцогт	47 050.6		**60 269.7**		128.1%	↑
Эрдэнэсант	71 528.3		**91 442.6**		127.8%	↑
Өндөрширээт	30 550.2		**36 018.0**		117.9%	↑
Угтаал	72 975.1		**82 872.0**		113.6%	↑
Зуунмод	1385 383.2		**1553 303.3**		112.1%	↑
Бүрэн	42 767.9		**47 879.0**		112.0%	↑
Баяндэлгэр	38 794.4		**43 049.8**		111.0%	↑
Дэлгэрхаан	26 231.9		**29 045.3**		110.7%	↑
Борнуур	110 109.8		**120 219.3**		109.2%	↑
Баянжаргалан	35 405.4		**33 139.4**		93.6%	↓
Архуст	57 351.8		**51 538.3**		89.9%	↓
Баян	137 797.8		**117 849.6**		85.5%	↓
Баян-Өнжүүл	44 175.9		**35 721.4**		80.9%	↓
Баянцагаан	114 668.4		**50 214.9**		43.8%	↓
Төвлөрсөн	-191 024.3		**47 244.8**		-24.7%	↓
	4434 983.1		6214 335.8		**140.1%**	

Орон нутгийн төсвийн орлого 4.5 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 144.3 хувиар биелэлээ. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 1.4 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 205.3 хувь биелж Баян-Өнжүүл, Аргалант, Архуст, Баянхангай, Баянжаргалан, Баяндэлгэр сумд 15.5-0.7 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 3.1 тэрбум ₮ болж 127.5 хувь биелж Баянцагаан, Баян, Баян-Өнжүүл, Архуст, Баянжаргалан, Зуунмод, Эрдэнэсант, Жаргалант, Угтаал, Бүрэн, Баянчандмань, Өндөршрээт сумд төлөвлөгөө 30.6-2.2 хувиар тасалдууллаа.

Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарын нийт зээлийн багц зээлдэгчийн тоо 33263, зээлийн багцын дүн 159.6 тэрбум ₮, зээл авсан зээлдэгчийн тоо 13792 олгосон зээлийн дүн 35.0 тэрбум ₮ боллоо.



Иргэдийн хувийн хадгаламжинд 4 сарын 30-ний байдлаар хугацаатай хадгаламж 51.9 тэрбум ₮, хугацаагүй хадгаламж 16.6 тэрбум ₮ байна.



Иргэдийн харилцах дансны үлдэгдэл 4 сарын 30-ны байдлаар 124234 иргэний 12.9 тэрбум ₮ боллоо.

ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.3-1.5 хувь, хугацаатай доод хүү 0.1-0.7 хувь, хугацаагүй дээд хүү 0.6 хувь, хугацаагүй доод хүү 0.1-0.6 хувьтай байна.



а. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2018 оны 4 дүгээр сард 2015 оны эцсээс 12,7 хувь; өмнөх оны мөн үеэс 6,3 хувь; оны эхнээс 2,9 хувь; өмнөх сараас 0,6 хувиар тус тус өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 6,3 хувиар өсөхөд хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 13,2 хувь; зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 11,0 хувь; орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 10,9 хувь; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ дүнгээрээ 6,7 хувь; тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 6,0 хувь; бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 5,7 хувь; гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнэ дүнгээрээ 5,3 хувь; эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3,9 хувь; хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2,9 хувь; амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2,9 хувиар өссөн нь голлон нөлөөлж холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ 0,9 хувиар буурчээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 4 дүгээр сард өмнөх сараас 0,6 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 1,3 хувь; гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 1,3 хувь; зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0,9 хувь; согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн үнэ дүнгээрээ 0,7 хувь; тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 0,5 хувь; хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0,5 хувь өссөн нь голлон нөлөөлжээ.

2018 оны 4 дүгээр сард өмнөх сараас хэрэглээний сагсны 238 нэрийн бараа, үйлчилгээний 8,4 хувийнх нь үнэ өсөж, 5,5 хувийнх нь үнэ бууран 83,6 хувийнх нь үнэ тогтвортой байв.




Махны үнэ
нэг кг-ийн үнэ
төгрөгөөр
10000
8000
6000
4000
2000
0
7000
8500
10000
8500
8250
8000
7750
6800
7500
8000
7500
7500
7500
6250
2012 - 04
2013 - 04
2014 - 04
2015 - 04
2016 - 04
2017-04
2018 - 04
хонины
үхрийн


2018-04/2015-12
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ
97.9
Амралт,чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ
103.4
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш
107.9
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа
109.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ
109.9
Тээвэр
110.6
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа
111.2
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис
112.0
ЕРӨНХИЙ ИНДЕКС
112.7
Бусад бараа, үйлчилгээ
114.4
Боловсролын үйлчилгээ
116.5
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ
116.9
Хувцас, бөс бараа, гутал
125.8
Хувь


2018-04/2017-04
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ
99.1
Боловсролын үйлчилгээ
100.1
Амралт,чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ
102.9
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа
102.9
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ
103.9
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа
105.3
Бусад бараа, үйлчилгээ
105.7
Тээвэр
106.0
ЕРӨНХИЙ ИНДЕКС
106.3
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис
106.7
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш
110.9
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ
111.0
Хувцас, бөс бараа, гутал
113.2


2018-04/2017-12
Боловсролын үйлчилгээ
99.9
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ
100.0
Бусад бараа, үйлчилгээ
100.0
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ
100.7
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш
100.7
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ
100.9
Амралт,чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ
101.6
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис
102.0
ЕРӨНХИЙ ИНДЕКС
102.9
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа
103.1
Хувцас, бөс бараа, гутал
103.1
Тээвэр
103.8
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа
106.3
Хувь



б. Хөдөөд 2018 оны 4-р сард бараа үйлчилгээний үнэ тариф суурь он буюу 2015 оны 12 сартай харьцуулахад 8,9%, 2017 оны 4-р сартай харьцуулахад 6,1%-аар тус тус өсч, өмнөх сартай харьцуулахад 0,7%-аар буурав.

Хөдөө аж ахуй

Төл бойжилт

5 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 47.9 хувь 1018.7 мянган хээлтэгч мал төллөж, 1036.0 мянган төл гарсны 93.3 хувь 966.2 мянган төл бойжиж байгаа нь урьд оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 23.6 хувь буюу 314.6 мянгаар; бойжиж буй төл 26.9 хувь 356.0 мянгаар тус бүр буурч; 2009-2017 оны мөн үеүдийн дунджаас төллөсөн хээлтэгч 0.6 хувь 6.5 мянгаар, бойжиж буй төл 2.9 хувь 28.4 мянгаар тус бүр буурлаа.

Оны эхний төллөх насны ингэний 18.8; гүүний 11.9; үнээний 22.6; эм хонины 54.0; эм ямааны 49.0 хувь нь тус бүр төллөв.



Төл бойжилтын хувийг газрын зургаар харуулбал

	Интервал-төлөөр	Сумын тоо
	61.9-93.5	7
	93.6-97.7	9
	97.8-99.0	7
	99.1-100.0	4





Гарсан төлийн 8.7 хувь болох 69793 толгой төл хорогдсон нь урьд оны мөн үеэс 2.7 дахин буюу 51126 төлөөр өсч; 2009-2017 оны мөн үеүдийн дунджаас 87.2 хувь буюу 32508 төлөөр өслөө. Гарсан ботгоны 8.7, унаганы 9.3, тугалын 5.7, хурганы 6.2, ишигний 7.7 хувь нь тус бүр хорогдов. Хамгийн их хорогдолтой 5 сум Дэлгэрхаан, Бүрэн, Алтанбулаг, Баян-Өнжүүл, Эрдэнэсант сумд гарсан төлийнхөө 38.1-4.9 хувь буюу 27058-6562 төл хорогдуулсан нь аймгийн бүх төлийн хорогдлын 81.0 хувийг (бүгд 56541 төл) эзлэв.

Том малын зүй бус хорогдол

5 сарын 1-ний байдлаар оны эхний малын 2.9 хувь буюу 134301 том мал зүй бусаар хорогдсон нь урьд оны мөн үеэс 2.8 дахин буюу 99041 толгойгоор, 2009-2017 оны мөн үеүдийн дунджаас 89.6 хувь буюу 63476 толгойгоор тус тус өслөө. Хамгийн их хорогдолтой 5 сум Бүрэн, Баян-Өнжүүл, Баянжаргалан, Алтанбулаг, Эрдэнэсант сумд оны эхний малынхаа 9.3-1.7 хувь буюу 34045-6704 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх хорогдлын 65.4 хувь (бүгд 87990) эзлэв.

Оны эхний тэмээний 0.4, адууны 4.3; үхрийн 4.8; хонины 2.1; ямааны 3.4 хувь нь тус бүр хорогдов. Бүх зүй бусаар хорогдсон малын 3.1 хувь нь өвчнөөр, 42.8 хувь нь хээлтэгч мал эзлэв.


Хорогдсон том малын хувийн жин-төрлөөр
Тэмээ 0.01%
Адуу 12.07%
Үхэр 11.20%
Ямаа 38.73%
Хонь 38.00%

Том малын хорогдол-эхний 4 сард
Малгай тоо
500
450
400
350
300
250
200
150
100
50
0
134.30
2009 2010 2011 2012 2013 2014 2015 2016 2017 2018
Онууд


Том малын хорогдолын оны эхний малд эзлэх хувь-
(эхний 4 сард)
Хувь
16.0%
14.0%
12.0%
10.0%
8.0%
6.0%
4.0%
2.0%
0.0%
12.82%
0.52%
0.31%
0.38%
0.61%
0.18%
0.66%
1.55%
0.75%
2.87%
2009 2010 2011 2012 2013 2014 2015 2016 2017 2018
Онууд



Том малын зүй бус хорогдолыг оны эхний малд эзлэх хувийг газрын зургаар харуулбал

	Интервал-малаар	Сумын тоо
	0.1-0.9	9
	1.0-2.2	7
	2.3-4.0	7
	4.1-9.3	4
	Хорогдолгүй	

Сумын хилийн зааг



АЖ ҮЙЛДВЭР

Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2018 оны эхний 4 сард (2010 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 7.5 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2017 оны мөн үеэс 47.8 хувь буюу 6.5 тэрбум ₮-өөр буурлаа.

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсан нь ашигт малтмал олборлолт өмнөх оноос 56 хувь буюу 4.3 тэрбум ₮-өөр буурсан нь нөлөөлөв.

Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Зуунмод, Жаргалант, Баянчандмань, Мөнгөнморьт сумд 47.7-1.7 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 94.6) хувийг эзлэв.

Оны эхний 4 сарын нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 32.7, боловсруулах үйлдвэрлэл 19.2, ашигт малтмал олборлолт 48.1 хувийг тус тус эзлэв.



Аж үйлдвэрийн салбарын дүнгээр 2018 оны эхний 4 сард оны үнээр 12.4 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн борлуулсан нь 2017 оны мөн үеийнхээс 39.7 хувь буюу 7.1 тэрбум ₮-аар буурлаа.

Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Зуунмод, Жаргалант, Баянчандмань, Мөнгөнморьт сумд 47.7-1.7 (эдгээр сумдын борлуулалт 92.5) хувийг эзлэв.

Оны эхний 4 сарын борлуулалтанд дулааны эрчим хүч 28.7, боловсруулах үйлдвэрлэл 21.9, ашигт малтмал олборлолт 50.2 хувийг тус тус эзлэв.

АҮ-ийн бүтээгдэхүүний борлуулалтыг газрын зургаар харуулбал

	Интервал-сая төг	Сумын тоо
	0.2-3.1	7
	3.1-12.5	7
	12.5-124.8	7
	124.8-5655.7	6

Аймаг, сумын хилийн зааг



Аж үйлдвэрийн салбарт оны эхний 4 сард нийт 1182 хүн ажиллаж бүтээмж 5.9 сая ₮ байгаа нь 2017 оны мөн үеэс 41.5 хувиар буурч, 2016 оны мөн үеэс 1.9 дахин нэмэгдлээ.

Ахуй үйлчилгээний байгууллагууд оны эхний 4 сард 336 цэгт 512 хүн ажиллаж 873.5 сая ₮-ийн орлого үйлчилгээний ажил хийж 320.9 сая ₮-ийн зардал гаргаж 71290 хүнд үйлчилжээ. Нийт орлогын 22.0 хувь нь оёдол, 12.0 хувь нь гутал, 4.2 хувь нь модон эдлэл, 27.5 хувь нь тээврийн хэрэгслийн болон ахуйн техникийн засвар, 20.1 хувь нь үсчин гоо засал, гэрэл зураг, 6.6 хувь нь халуун усны, 7.6 хувь нь бусад үйлчилгээний орлого эзлэв.



БАРИЛГА

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагууд 2018 оны эхний 4 сард 636.9 сая ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2016 оны мөн үетэй харьцуулахад 90,1 буюу 195,1 сая ₮-өөр өсөв.
Барилга угсралт, их засварын ажлын 8,7 хувь нь орон сууцны бус барилгад; 18,8 хувь нь орон сууцны барилгад; 72,5 хувь нь инженерийн барилга байгууламжид ногдлоо.



Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 4 сард 81.9 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 27.1 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.9 хувь буюу 8.0 сая ₮-өөр буурлаа.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 28.2 сая ₮ болсон ба нийт орлогын 70.1 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 29.8 хувийг албан бичгийн 6.2 хувийг зорчигчдын, 64.0 хувийг бусад орлого бүрдүүллээ.



ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ

2018 оны 1-р улирлын мэдээгээр Төв аймагт худалдааны чиглэлээр 201 аж ахуй нэгж, зочид буудал зоогийн газрын чиглэлээр нийт 36 ААНБ үйл ажиллагаа явуулж байна.

2018 оны худалдааны мэдээний түүвэрт 50 ААНБ сонгогдсон ба 36 нь үйл ажиллагаа явуулсан. Эдгээр газрууд 1 дүгээр улирлын мэдээгээр 4.9 тэрбум төгрөгийн орлого олжээ. Борлуулсан барааны өртөг нь нийт орлогын 99.0 хувийг эзэлж байна. Эдгээр 36 аж ахуй нэгжид нийт 84 ажилчин ажиллаж байгаагийн 48 нь эмэгтэй ажилчид ажиллаа.

Зоогийн газрын үйлчилгээ эрхэлдэг 11 аж ахуйн нэгж мэдээний түүвэрт сонгогдсон ба нийт орлого дүнгээр 114.1 сая төгрөг боллоо. Нийт орлогын 43.9 хувь нь хоолны орлогоос, 33.7 хувь нь бусад үйлчилгээний орлогоос бүрджээ. Нийт зардал 107.4 сая төгрөг байгаагийн 103.6 хувийг ажилчдын цалин, НДШ-д зарцуулжээ.

Зочид буудлын үйлчилгээ эрхэлдэг 5 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулсан. Эдгээр газруудын нийт орлого 471.5 сая төгрөг, нийт зардал 425.6 сая төгрөгт хүрэв. Орлого өнгөрсөн оны мөн үеэс 40.2 хувиар, хүлээн авсан зочдын тоо 1.4 дахин өсөв. Салбарт ажиллагчдын тоо 70, эмэгтэй 35 хүн байна.

Нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээ

2018 оны эхний 3 сард хүрээнд сонгогдсон нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээ үзүүлдэг аж ахуй нэгж байгууллагын орлого 6.1 сая.₮, зардалд 14.6 сая.₮ зарцуулжээ.

Төрийн бус байгууллага

2018 оны эхний 1-р улиралд орлого 54.8 сая ₮, зарлага 60.3 сая ₮ байгаа нь 2017 оны мөн үеэс орлого 51.9 хувиар буюу 59.4 сая ₮-өөр, зарлага 59.5 хувиар буюу 88.8 сая ₮-өөр тус бүр буурлаа. Хүрээнд сонгогдсон төрийн бус байгууллагын ажилчдын тоо 51 байгаагийн 30 буюу 58.8 хувь нь Зуунмод суманд байна. Хүрээнд сонгогдсон нийт 33 төрийн бус байгууллага байгаагийн 54.5 хувь буюу 18 нь үйл ажиллагаа явуулж байна.

Мэргэжлийн түр сургалт

2018 оны эхний 1-р улиралд түүврээр сонгогдсон мэргэжлийн түр сургалт явуулдаг аж ахуй нэгж байгууллагын орлого 8.9 сая ₮ байгаа нь өмнөх оны мөн үеэс 52.9 хувиар өсч, 8.6 сая ₮ зарцуулж сургалтанд 35 иргэн хамрагджээ.

Аялал жуучлал

2018 оны 1 улиралын байдлаар аялал жуучлалын үйлчилгээ эрхэлдэг 12 аж ахуй нэгж байгууллага түүвэрт хамрагдаж, 5 аж ахуй нэгж үйл ажиллагаа эхлээгүй 7 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж орлого 110.1 сая.₮, зарлага 107.6 сая ₮ боллоо.

Мал эмнэлэг

2018 оны 1 улиралын байдлаар мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлдэг 68 аж ахуй нэгжээс 38 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулсанаас орлого 76.8 сая ₮, зардал 67.8 ₮ болж, нийт 871200 мал үйлчилгээнд хамрагдлаа.